

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дүгээр сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын "08," гэсний дараа "10 дугаар бүлгийн 1002.90.20, 1003.90.20, 1004.90.20, 1005.90.20 дахь үндэсний код, 11 дүгээр бүлгийн 11.01 дэх зүйл," гэж, "22.09 дэх зүйл," гэсний дараа "23 дугаар бүлгийн 23.02 дахь зүйл," гэж тус тус нэмсүгэй.

2.Мөн тогтоолын хавсралтаар баталсан "Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ"-ний 10 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай үндэсний код нэмсүгэй:

10	-	1002.90.20	тэжээлийн (Хөх тариа)	5 хүртэл
	-	1003.90.20	тэжээлийн (Арвай)	
	-	1004.90.20	тэжээлийн (Овьёос)	
	-	1005.90.20	тэжээлийн (Эрдэнэшиш)-ийг Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор тус тус импортолсон бол	

3.Мөн тогтоолын хавсралтаар баталсан "Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ"-ний 23 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй:

23	23.02	-	Үр тариа ба буурцагт ургамлыг шигших, тээрэмдэх эсвэл бусад боловсруулалт хийх явцад гардаг хорголжилсон, эсвэл хорголжлоогүй хивэг, үртэс болон бусад үлдэгдлийг Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор импортолсон бол	5 хүртэл
----	-------	---	---	-------------

4.Мөн тогтоолын хавсралтаар баталсан “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ”-ний 11 дүгээр бүлгийн “7 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1 хүртэл” гэсэн хугацаанд заасан албан татварын хувь, хэмжээний “15” гэсний дараа “хүртэл” гэж, мөн бүлгийн “4 дүгээр сарын 1-нээс 7 дугаар сарын 1 хүртэл” гэсэн хугацаанд заасан албан татварын хувь, хэмжээний “5” гэсний дараа “хүртэл” гэж тус тус нэмсүгэй.

5.Энэ тогтоолыг 2025 оны ... дүгээр сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ